

Даланзадгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 3-р хуралдааны 2012 оны 12 сарын 18 -ны
өдрийндугаар тогтоолын хавсралт

ДАЛАНЗАДГАД СУМ / ХОТ/-ЫГ 2013 -2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Даланзадгад сум /хот/-ын Засаг даргаас Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутагт хэрэгжик байгаа үндэсний хөтөлбөр тогтоол шийдвэрүүд, тэдгээрийг дагалдан гарсан дэд хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2012 онд орон нутгийн сонгуульд оролцсон намуудын хөтөлбөр болон иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал санаачлагыг үндэслэн 4 жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө 5 бүлэг, 11 зорилт, 104 заалттайгаар боловсрууллаа.

Тус үйл ажиллагааны хөтөлбөрөөр бид 2016 он ба түүнээс цаашхи хугацаанд Даланзадгад сумын хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, нийгэм, эдийн засгийн өсөлтийг хадгалах хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийг түргэтгэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Даланзадгад сум /хот/-ыг 2013-2016 онд хөгжүүлэх сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь ирэх 4 жилд дараах үндсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

- Дээгүүр орлоготой Даланзадгад сум
- Дэлхийн боловсролтой Даланзадгад сум
- Дэд бүтэцтэй Даланзадгад сум
- Дагшин байгальтай Даланзадгад сум
- Дэгжин Даланзадгад сум

НЭГ. ДЭЭГҮҮР ОРЛОГОТОЙ ДАЛАНЗАДГАД СУМ

1.1 Эрүүл чийрэг, ажилтай, орлоготой өрх, гэр бүлийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

1. “Өрх, гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, шинэ ажлын байрыг бий болгон өрхийн амьжиргааг дээшлүүлж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлнэ.
2. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмзэг бүлэг зэрэг зорилтод бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлнэ.
3. “Эрүүл иргэн” хөтөлбөрийн хүрээнд сумын дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх замаар иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
4. “Сүү-тараг” аймгийн хөтөлбөрийн хүрээнд сумын дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх замаар эм болон хоол, хүнсний зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.
5. Жирэмсэн эх, хүүхдийн хяналт, тусламж үйлчилгээг чанаржуулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
6. Эрүүл мэндийн даатгалд хамрагдан 3 жилд өвчлөөгүй иргэнийг 1 удаа эрүүл мэндийн үнэ төлбөргүй оношлогоонд хамруулна.

1.2 Даланзадгад сумын эдийн засаг, төсөв санхүүгийн чадавхийг нэмэгдүүлж орон нутгийн хөгжлийг дэмжинэ.

7. Төсвийн шинэчилсэн хуулийг зохистой хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төсвийн төлөвлөлтийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн санхүүжилт, тайлагналт, хяналтыг сайжруулж ард иргэдэд нээлттэй “Шилэн түрийвч”-ийн бодлогыг нэвтрүүлнэ.
8. Төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд сумын татварын байцаагчдыг ЗДТГ-т татан байршуулж татварын шинэчилсэн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжилтэн, БЗД, иргэн, аж ахуй нэгжүүдэд сургалт, сурталчилгааг үе шаттай зохион байгуулан татвар төлөх нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлнэ.
9. Бүтээн байгуулалттай холбоотой Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагч иргэн байгууллага, ААН-үүдийн төлбөрийг норм орцын дагуу тооцон гүйцэтгэлээр орлогыг бүрэн тооцож төсөвт төвлөрүүлэн ажиллана

10. Засаг даргын албад, түүний харьяа бүхий Орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдэд хөндлөнгийн болон дотоод аудит хийж бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон, үйл ажиллагааны менежментийг сайжруулна.
11. Орон нутгийн иргэдийн ажиллаж амьдрах, эрүүл тохилог, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор “Орон нутгийн хөгжлийн сан”-г иргэд олон нийтийн оролцоотойгоор төлөвлөж, зарцуулна.
12. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт оруулан ил тод байдлыг хангах замаар төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлнэ.
13. Улсын болон орон нутгийн төсөв, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгуулах, өмч, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.
14. Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн болон газрын гэсэн ангиллаар явуулж өмчийн алба болон үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулна.
15. Төрийн сангийн тогтолцоог иж бүрэн нэвтрүүлж, дотоод хяналтыг сайжруулан, ажиллагсдын чадавхийг бэхжүүлэх замаар төсвийн тогтвортой, иж бүрэн, үнэн зөв, ил тод, зохистой хариуцлагатай байх зарчмыг хангана.

1.3 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

16. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийт мал сүргийг ээмэгжүүлэн малын бүртгэл мэдээллийн санд хамруулна.
17. Малын индексжүүлсэн даатгалыг давхар даатгалд хамруулах замаар олон улсын стандартын дагуу мал сүргийг бүрэн бүртгэж, даатгалд хамрах хүрээг өргөжүүлнэ.
18. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж, өндөр ашиг шимт эрчимжсэн болон туслах аж ахуйг бус, нутгийн боломж нөхцлийг харгалзан хөгжүүлж, мал аж ахуй, газар тариалан хосолсон “Загвар ферм”-ийг байгуулна.
19. Мал эмнэлэг, үржлийн үйл ажиллагааг сайжруулан, мал аж ахуйд биотехнологийн дэвшилтэт аргыг өргөнөөр нэвтрүүлж, мал үржлийн хувийн хэвшлийг дэмжиж, хамтарч ажиллана.
20. Цөөн малтай малчин өрхүүдийг малжуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
21. Газар тариалангийн услалтын системийг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлж, хүнсний ногооны тариалан эрхлэх цогцолборыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулан, тариалах талбай, хураан авах ургацыг нэмэгдүүлнэ.
22. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөр гүн өрмийн худаг гаргана.
23. Малчдын үүсгэл санаачилгаар хийгдэж буй бэлчээр хашиж хамгаалах, сайжруулах, гар худаг гаргах, малын тэжээлийн ургамал тариалах зэрэг үйл ажиллагааг дэмжиж, урамшуулна.
24. Зохиомлоор бороо оруулах технологийг сайжруулан, нийт газар нутгийг хамрах хүртээмжийг нэмэгдүүлж, борооны усыг хөдөө аж ахуйд ашиглах хөв цөөрмийг тохиромжтой газар нутгуудад байгуулах асуудлыг судлан шийдвэрлэнэ.
25. Төлөөр нь өсгөсөн тэмээ тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг үргэлжлүүлэн олгоно.
26. Малчдын нөхөрлөл, хоршоодыг дэмжиж, “Зөвлөгөө-мэдээллийн төв”-ийг байгуулан, малчдын өдөртэй болгоно.
27. Хоршоодыг дэмжиж чадваржуулах, тогтмол үйл ажиллагаатай хоршоодын тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
28. Олон улсын стандартад нийцсэн хүнсний чанарын лабораторыг байгуулахад орон нутгийн зүгээс шаардлагатай туслалцааг үзүүлэн хамтран ажиллана.
29. Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механижуулж, хүлэмж, зоорийн аж ахуйг хөгжүүлэн төмс, хүнсний ногоо, сүү, өндөгний хэрэгцээг тодорхой хувиар дотооддоо хангах арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1.4 Орон нутгийн хөгжилд үр нөлөөтэй үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ.

30. Ажлын байрыг нэмэгдүүлэн, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор эрдэс түүхий эд, нүүрс, хуванцар боловсруулалт, замын битум, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах зэрэг хүнд, хөнгөн үйлдвэрийг, уул уурхайг дагалдсан боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

31. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг төсөл хөтөлбөрт хамруулах болон хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжин үйлдвэрийн тоог ахиулж бараа бүтээгдэхүүний чанар хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлэхэд эрх зүйн туслалцаа үзүүлнэ.
32. Үйлдвэрлэл эрхлэгчид болон бизнес эрхлэгчид, уул уурхайн компаниудтай хамтран ажиллах, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх
33. Өндөр технологийг нутагшуулах, судалгаа, туршилт хийх Инновацийн судалгааны төвийг Даланзадгад суманд байгуулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлнэ.
34. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх зорилго бүхий “Хөдөө аж ахуйн бирж”-ийг тус суманд төвлөрүүлэн байгуулна.
35. Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжин, хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг тогтмол зохион байгуулж, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах ажлын хүрээнд хоёроос доошгүй брэнд бүтээгдэхүүнд “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх эрх олгох үйл ажиллагаанд хамтран оролцно.
36. Эрүүл ахуйн шаардлага хангасан, стандарт шаардлагад нийцэхүйц “Хүнсний худалдааны төв” байгуулах ажлыг аймаг, орон нутгийт хамтран зохион байгуулна
37. Газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг сайжруулах “Капитал-Хөрөнгө” хөтөлбөр хэрэгжүүлэн санхүүгийн эргэлтэд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.
38. Хөдөлмөрийн бүтээмжийг үнэлэх урамшууллын системийг боловсронгуй болгон шагнал урамшууллын шинэчилсэн бодлого хэрэгжүүлнэ
39. Төрийн албан хаагчийг ажлын үр дүнгээр урамшуулан нийгмийн баталгааг хангах нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

ХОЁР. ДЭЛХИЙН БОЛОВСРОЛТОЙ ДАЛАНЗАДГАД СУМ

2.1 Олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц соёл, боловсролтой иргэнийг төлөвшүүлнэ.

40. Эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн “Зөв Монгол хүүхэд” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, цэцэрлэг, сургууль болон эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
41. Хүүхдийн авьяас, чадвар, хувь шинжийг нээн хөгжүүлэх “Авьяас” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
42. Үндэсний Монгол бичиг сургах аяныг уламжлал болгон зохион байгуулж “Засаг даргын Нэрэмжит” шагналыг бий болгоно.
43. Орон нутагт эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжлээр гадаад, дотоодын их, дээд сургуульд оюутан сургаж бэлтгэх, боловсон хучнийг давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажилд сумын иргэдийг хамруулан ажиллана.
44. Байгууллагын хүний нөөцийн чадавхи, мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ
45. Малын эмч, мал зүйч мэргэжлээр их, дээд сургуульд суралцаж байгаа малчин өрхийн хүүхдийн сургалтын зардлыг орон нутгаас санхүүжүүлж, мал аж ахуйг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
46. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны барилга барих, өргөтгөх, засварлах, тохижуулах замаар хүүхдийн ая тухтай сурч, хүмүүжих орчныг бүрдүүлнэ.
47. “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтийг дэмжсэн эрүүл хүнсээр хангах асуудлыг шийдвэрлэж, хангамж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.
48. Биеийн тамирын хичээлийг хүүхэд бүрийн эрүүл өсөн хөгжих, авьяасыг хөгжүүлэхэд чиглүүлж, спорт заалыг тоног төхөөрөмжөөр хангаж, биеийн тамирын талбайг тохижуулна.
49. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг зориулалтын сурх бичиг, тоног төхөөрөмжөөр хангах, суралцах орчин нөхцлийг бүрдүүлнэ.
50. Албан бус боловсролыг насан туршийн боловсролын хэлбэрт шилжүүлэн, сургалтын агуулга, арга зүй, сурх бичиг, орчин хэрэглэгдэхүүн, чанарын үнэлгээ, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх боломж, нөхцлийг бүрдүүлнэ.
51. Олон улсын стандартын барилга байгууламжийн шаардлагад нийцсэн Уул уурхайн жишиг сургуулийг суманд байгуулахыг дэмжинэ.
52. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулж, элсэгчдийг ажил олгогчийн гэрээ, захиалга дээр тулгуурлан төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцлийг бүрдүүлнэ.

53. Мэргэжлийн урлагийн байгууллагын хэв шинжийг өмнийн говийн өнгө төрх, бүжиг дуу хуур, ерөөл магтаал, давтагдашгүй өв соёлын баялаг, өв санг орчин үеийн соёл, урлагтай уялдуулан хөгжүүлнэ.
54. Өмнөговийн түүх, уламжлал, соёл, зан заншлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Батмөнх Даян хаан, ерөөл магтаал, үндэсний спорт, өвөрмөц зан үйл зэрэг сэдэв, төрлөөр уралдаан тэмцээн, үйл ажиллагааг жил бүр уламжлал болгон зохион байгуулна.
55. Аймгийн номын сангийн сан хөмрөгийг үе шаттайгаар баяжуулна.
56. Иргэдийн эрх зүйн болон эрүүл мэндийн боловсрол, хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх, “Иргэний боловсрол” хөтөлбөрийг эрх зүйн хөтөч, ухуулагч, эрүүл мэндийн сургагч нарын мэргэшсэн багаар дамжуулан нийгмийн бүлгүүдэд чиглүүлэн хэрэгжүүлнэ.
57. Иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг сайжруулан, “Эрх зүйн туслалцаа үзүүлэх” төвийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.

ГУРАВ. ДЭД БҮТЭЦТЭЙ ДАЛАНЗАДГАД СУМ

3.1 Орон, нутгийн дэд бүтцийг хөгжүүлэн эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах замаар бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлнэ.

58. Шинээр бий болсон хороолол, хотхон, эзэмшил, өмчлөлийн газруудад инженерийн болон шугам сүлжээ, дэд бүтцийг барьж байгуулахад орон нутгийн зүгээс зохих дэмжлэгийг үзүүлэн хамтран ажиллана.
59. Цахилгаан дамжуулах агаарын шугамыг өргөтгөж, төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдох ажилд зохих дэмжлэгийг үзүүлэн дэмжиж ажиллана.
60. Иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг сайжруулж, мэдээллийн дэд бүтцийг нийтийн хүртээл болгоход иргэдийг уриалан хамтран ажиллана.
61. Статистикийн мэдээлэл боловсруулалтын үр ашигтай, шуурхай байдлыг бүх шатанд хангасан техник, технологийг нэвтрүүлэн хүчин чадлыг нэмэгдүүлж, мэдээллийн цахим сан бий болгоно.

3.2 Төв, суурин газрын орчны эрүүл ахуй, ая тухтай байх нөхцлийг сайжруулна.

62. Говийг ойжуулах, цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааг Мод үржүүлгийн газар, Ойн анги, Ботаникийн хүрээлэн байгуулах замаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
63. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хороололд дэд бүтцийг нэмэгдүүлж, утаагүй түлшний шинэ технологийг нэвтрүүлж агаарын бохирдол, тоосжилтийг хянах агаарын чанарын хяналтын тоног төхөөрөмжийг суурилуулна.
64. Үерийн усыг зайлцуулах хамгаалалтын даланг барьж байгуулах ажилд иргэдийн саналыг авч зохистой хувилбарыг санал болгон хамтран ажиллана.
65. Нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг баруун бүсийн сумдтай холбох хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулахад орон нутгийн зүгээс бодлогоор дэмжин ажиллана.
66. Олон улсын Нисэх онгоцны буудлыг барьж ашиглалтад оруулахад орон нутгийн зүгээс зохих дэмжлэгийг үзүүлэн хамтран ажиллана.
67. Төв болон гэр хороололд шинээр авто зам, явган хүний замыг барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
68. Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банкны хөрөнгө оруулалтаар тус суманд цэвэрлэх байгууламж барих ажилд орон нутгийн зүгээс зохих дэмжлэгийг үзүүлнэ.
69. Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэн төрөөс төсөл хөтөлбөрөөр дэмжин ажиллана.
70. Даланзадгад сумын хүн амын үндны хоёрдахь эх үүсвэрийг шинээр барьж байгуулах ажилд орон нутгаас зохих дэмжлэгийг үзүүлэн хамтран ажиллана.
71. Даланзадгад-Тавантолгой-Зүүн баян чиглэлийн төмөр замыг барих төрийн бодлого чиглэлтэй уялдуулан, орон нутгаас зохих арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
72. Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, явган зам, нийтийн үйлчилгээний газруудыг гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээнд иж бүрэн хамруулна.
73. Боловсролын байгууллагын менежментийн мэдээллийн системийг байгуулж, мэдээллийн технологийг сургалтын орчинд өргөнөөр ашиглана.
74. Төрөөс иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын орчинг утасгүй интернетийн бүсэд хамруулна.

75. Сумын төв, гэр хорооллыг интернэтжүүлэх ажлыг эрчимжүүлж, энэ чиглэлд хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

ДӨРӨВ. ДЭГЖИН ДАЛАНЗАДГАД СУМ

4.1 Орчин үеийн шийдэлтэй барилга, хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлж Даланзадгад сумыг улсын зэрэглэлтэй 4 дэх хот болгон хөгжүүлнэ.

76. Хог хаягдлын орчин үеийн шийдэлтэй техник, технологийг нэвтрүүлнэ.
77. Ногоон хот төсөл боловсруулан “Эко–ДАЛАНЗАДГАД” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Сумын төвд хүүхэд залуучуудын чөлөөт цагийг өнгөрөөх соёл амралтын төв байгуулах асуудлыг судлан эхлэлийг тавина.
78. Даланзадгад сумыг бүсийн хөгжлийн тулгуур төв болгох зорилгоор хот төлөвлөлтийг оновчтой боловсруулан хэрэгжүүлнэ. /Газар төлөвлөлт/
79. “1000 айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сумын төвд баригдах 300 айлын орон сууцны барилгын ажлын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.
80. Даланзадгад суманд Автовокзал оношлогооны төвийг барьж байгуулах ажилд орон нутгийн зүгээс зохих дэмжлэгийг үзүүлэн хамтран ажиллана.
81. Сумын хэмжээнд төрийн захиргааны болон нийгэм, соёлын салбаруудын барилга байгууламжийн засвар шинэчлэлтийн ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, ашиглалтыг сайжруулна.
82. Даланзадгад сумын гэр хорооллын газрыг иргэдийн оролцоотой шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөх замаар иргэд, оршин суугчдын амьдрах таатай нөхцлийг бүрдүүлнэ. Сумын хилийн цэсийг мэргэжлийн байгууллагатай хамтран баг тус бүрээр нарийвчлан гаргана.
83. Говийн бүсийн эмчилгээ оношлогооны төв, 50 ортой амаржих газар, 1200 хүүхдийн суудалтай сургууль, Хүүхдийн ордон, аймгийн Музей, Төв номын сан зэрэг нийгмийн салбарын барилга байгууламжийг шинээр барьж, иргэдэд нийгмийн суурь үйлчилгээг ая тухтай хүргэх орчин бүрдүүлнэ.
84. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Хөгжлийн төв”-ийг байгуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал хүсэлтийг авч тэдний эрх ашигт нөлөөлөх зөв зүйтэй асуудлыг дэвшүүлэн хамтран ажиллана.
85. Эрүүл мэндийг дэмжих төв, клуб байгуулахыг бодлогоор дэмжиж, “Эрүүл хот, сургууль, цэцэрлэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх таатай орчныг бүрдүүлнэ.

4.2 Аюулгүй амгалан орчинг бүрдүүлнэ.

86. “Архигүй Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэн архи, тамхигүй орчин бүрдүүлж тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоог батлагдсан нормативд барьж “Эрүүл идэвхтэй амьдралын клуб”-ыг суманд байгуулахыг дэмжинэ.
87. Гадаадын иргэдийн бүртгэл хяналтыг сайжруулан, Сумын гадаадын иргэнийг бүртгэх журмыг хэрэгжүүлэн тогтмолжуулан ажиллана.
88. Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхи санаачилгад суурисан “Иргэдийн зөвлөл” байгуулан амгалан тайван амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
89. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулна.
90. Сумын цэрэг иргэний бүртгэл, онцгой байдлын үеийн ажиллагааны бэлэн байдлын нөөцийг стандарт шаардлагын дагуу төлөвлөн хангаж ажиллана.

4.3 Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

91. “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Иргэд ААН-ын дунд орчноо тохижуулах аяны хүрээнд явган хүний зам болон авто замын ашиглалтанд сайнаар нөлөөлөх санал санаачлагыг дэмжин ажиллана.

92. “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төрийн анхан шатны үйлчилгээг иргэдэд ойртуулах нөхцлийг сайжруулна.
93. Сумын үйл ажиллагааг иргэддээ нээлттэй байх, иргэдийн оролцоотой асуудлаа шийддэг байхад чиглэсэн ажил зохион байгуулж “Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “ тухай хууль, Нийтийн зар мэдээний журам, Сумын дүрэм, багийн ИНХ-ын дүрмийг боловсруулан баттуулж хэрэгжүүлж ажиллана.
94. Сумын Засаг даргын Тамгын газарт “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг идэвхижүүлэн, ОНХА /Олон нийттэй харилцах алба/, “Иргэдээ сонсох 1515 төв”-ийг нээн ажиллуулж иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах, олон нийтийн санал асуулга явуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
95. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зарчмыг баримталж, төр, бизнес, иргэний нийгмийн байгууллагын 3 талт түншлэлийг өргөжүүлнэ.
96. Төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэдэг “Нэг цонх”-ны үйлчилгээний ажлыг идэвхижүүлэн ажлын байрыг тохижуулан сайжруулж, Нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн байр ашиглалтанд орох хүртэл хугацаанд төрийн үйлчилгээг тасралтгүй ажиллуулах нөхцлөөр хангана.
97. Даланзадгад сумын архивын байрыг стандартад нийцуулж, цахим тогтолцоо бүрэн нэвтрүүлнэ.
98. Төр захиргааны үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ТАВ. ДАГШИН БАЙГАЛЬ ТАЙ ДАЛАНЗАДГАД СУМ

5.1 Байгаль орчны менежментийг боловсронгуй болгож,.gov нутгийнхаа байгалийг унаган төрхөөр нь хадгална.

99. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын гаргаж байгаа хог хаягдалд үнэлгээ өгч ахуйн хаягдлаас ялгаатай жишиг үнийг ИТХ-аар тогтоолгон мөрдүүлнэ.
100. Усны зохистой удирдлагыг бий болгон Зөвлөл байгуулж, гүний ус, түүний ай савыг хамгаалах, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй усны хяналтын тогтолцоог сайжруулахад орон нутгийн зүгээс санаачлагатай хамтран ажиллана.
101. Говийн нөхцөлд ургадаг мод, бутлаг ургамлыг тарималжуулсан, байгаль хамгаалах үйлсэд идэвхтэй оролцож буй иргэн, аж ахуй нэгж, байгууллага, нөхөрлөл, ТББ-ыг дэмжих урамшууллын системийг боловсронгуй болгон хэрэгжүүлнэ.
102. Карьер болон шугам сүлжээний нөхөн сэргээлтийг байгаль хүн, мал амьтанд нөлөөлөлгүйгээр бүрэн стандартын дагуу хийлгэж ААН, хувь хүний хариуцлагыг өндөржүүлэн ажиллана.
103. Хөрсний бохирдолыг багасгах зорилгоор мэдээллийн нэгдсэн сүлжээтэй болж, зөрчил арилгах шагнал урамшууллын системийг хэрэгжүүлэн ажиллана.
104. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй болон явуулах сонирхолтой ААН, нөхөрлөл, иргэн, сайн дурын хувь хүмүүсийн хөдөлгөөн санаачлагыг дэмжин урамшуулж ажиллана.

ДАЛАНЗАДГАДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР